



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2020 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 08

Мандалговь

Б.Түвшин-Эрдэнийг Сайнцагаан сумын  
“Цэгцбилиг” сургуулийн захирлын албан тушаалд  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын Төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Сайнцагаан сумын “Цэгцбилиг” сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Буджавын Түвшин-Эрдэнэ 68.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Түвшин-Эрдэний холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь  
салбар зөвлөлийн 2022 оны ...<sup>02</sup> дугаар сарын  
...<sup>02</sup>-ны өдрийн ...<sup>06</sup> дугаар тогтоолын хавсралт



**Сайнцагаан сумын “Цэгцбилиг” сургуулийн захирлын  
албан тушаалд нэр дэвшүүлсэн Б.Түвшин-Эрдэний тухай  
дүгнэлт**

1. Б.Түвшин-Эрдэнэ нь 1984 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 38 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2002-2007 онд Шинжлэх ухаан техникийн их сургуулийг компьютерын инженер мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2007 оноос эхлэн Цэгцбилиг сургуульд мэдээлэл зүйн багш, сургалтын менежер, захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа.
4. Б.Түвшин-Эрдэнэ нь тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Сайнцагаан сумын “Цэгцбилиг” сургуулийн захирлын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ